



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/381

Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгагдсан Хангал сумын Хялганат тосгоны ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Бурхууд” ХХК-тай 183 583 455 /нэг зуун наян гурван сая таван зуун наян гурван мянга дөрвөн зуун тавин тав/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т олгосугай.

2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд гэрээ байгуулж, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т үүрэг болгосугай.

3. Гэрээний хугацаанд дээрх ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Бурхууд” ХХК /Т.Болдбаатар/-д даалгасугай.

4. Энэхүү ажлын санхүүжилтыг холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ